



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ 2022 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: ДАА-2023/111/НА-СТА-ТШЗ



Дархан-Уул аймаг  
2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: [batsurenu@audit.gov.mn](mailto:batsurenu@audit.gov.mn)

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

**Аудитор Э.Одгэрэл**

Утас: 70373089 Цахим хаяг: [odgerele@audit.gov.mn](mailto:odgerele@audit.gov.mn)

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
Асуудлыг онцолсон хэсэг.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА Ө.АРИУНБААТАР  
ТАНАА

2023.02.20 № 41  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хараа-Ерөө голын сав газрын захиргаа нь 2022 онд 11 орон тоотой төсөв батлуулсан ч 3-7 орон тооны дутагдалтай ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал зарцуулагдаагүй үлджээ. Тайлант хугацаанд аймгийн төрийн албаны зөвлөлд санал хүргүүлснээр 5 ажлын байранд шалгаруулалт зарлаж тэнцсэн 2 хүний томилгоо хийгджээ.

**Аудитын гол асуудал**

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01-А/308 дугаар захирамжаар тус захиргааны 37,500.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг дуусгавар болгосон ч ТӨБЗГ бүртгэлээс хасах шийдвэр гаргаагүй тул төсвийн захирагч санхүүгийн тайлан дахь биет бус хөрөнгийн дүнгээс хасаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

009020042

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хараа-Ерөө голын сав газрын захиргааны даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 69 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 86.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,144,487.00</b>	<b>12,776,450.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,144,487.00	12,776,450.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14,144,487.00	12,776,450.00
35410	Бичиг хэргийн материал	795,850.00	613,950.00
35420	Аж ахуйн материал	2,012,237.00	1,501,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,732,800.00	5,557,800.00
35470	Бусад хангамжийн материал	5,603,600.00	5,102,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>103,200,607.50</b>	<b>81,140,786.76</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	103,200,607.50	81,140,786.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	85,480,607.54	43,530,786.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,269,182.50	55,269,182.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,743,070.40)	(18,511,161.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,597,926.56	26,597,926.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,082,674.44)	(21,352,641.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,660,628.26	11,449,628.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,221,384.94)	(9,922,147.62)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	37,719,999.96	37,609,999.92
39301	Програм хангамж	330,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(110,000.04)	(220,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,500,000.00	37,500,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>117,345,094.50</b>	<b>93,917,236.76</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>117,345,094.50</b>	<b>93,917,236.76</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	117,345,094.50	93,917,236.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,500,000.00	37,500,000.00
51101	Өмч: - төрийн	37,500,000.00	37,500,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	79,845,094.50	56,417,236.76
51210	Өмнөх үеийн үр дүн	79,845,094.50	79,845,094.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	(23,427,857.74)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>117,345,094.50</b>	<b>93,917,236.76</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>238,908,080.00</b>	<b>154,399,700.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,466,380.00</b>	<b>1,004,700.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	46,466,380.00	1,004,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,289,900.00	912,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,000.00	700,000.00
120009	Бусад орлого		212,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	45,439,900.00	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	176,480.00	92,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>192,441,700.00</b>	<b>153,395,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>189,781,700.00</b>	<b>151,755,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	189,781,700.00	151,755,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,660,000.00</b>	<b>1,640,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,660,000.00	1,140,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>208,009,915.20</b>	<b>177,827,557.74</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>208,009,915.20</b>	<b>177,827,557.74</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>151,572,651.21</b>	<b>132,214,470.52</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>93,158,252.00</b>	<b>78,795,931.20</b>
210101	Үндсэн цалин	79,252,793.00	65,570,005.00
210102	Нэмэгдэл	11,338,331.00	7,161,884.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,567,128.00	2,106,500.00
210104	Урамшуулал	-	3,957,542.20
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,583,891.10</b>	<b>9,849,491.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,803,878.54	6,697,654.34
210202	Тэтгэмжийн даатгал	945,002.99	787,959.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	756,002.59	630,367.47
210204	Ажилгүйдлийн даатгал	189,000.44	157,591.84
210205	Эрүүл мэндийн даатгал	1,890,006.54	1,575,918.62
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,516,800.00</b>	<b>10,922,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	720,000.00	720,000.00
210304	Байрны түрээс	9,796,800.00	10,202,800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,496,644.00</b>	<b>6,504,637.00</b>
210401	Бичиг хэрэг	1,325,920.00	488,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,360,000.00	2,980,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,002,860.00	1,120,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	807,864.00	1,915,737.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>405,700.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	405,700.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>236,000.00</b>
210604	Урсгал засвар	-	236,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,730,000.00</b>	<b>2,390,000.00</b>



210702	Дотоод албан томилолт	1,730,000.00	2,390,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,257,889.91</b>	<b>568,090.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,550,461.91	-
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,500.00	161,090.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	424,828.00	407,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,829,174.20</b>	<b>22,541,820.74</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,619,174.20	22,271,820.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,437,263.99</b>	<b>45,613,087.22</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,841,200.00</b>	<b>-</b>
213207	Тэтгээрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,841,200.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,596,063.99</b>	<b>45,613,087.22</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,596,063.99	45,613,087.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>30,898,164.80</u></b>	<b><u>(23,427,857.74)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>30,898,164.80</u></b>	<b><u>(23,427,857.74)</u></b>




## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>193,291,700.00</b>	<b>154,095,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>850,000.00</b>	<b>700,000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	850,000.00	700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	850,000.00	700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,000.00	700,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>192,441,700.00</b>	<b>153,395,000.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	189,781,700.00	151,755,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,660,000.00	1,640,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,660,000.00	1,140,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>193,291,700.00</b>	<b>154,095,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193,291,700.00</b>	<b>154,095,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>136,854,436.01</b>	<b>108,481,912.78</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,158,252.00	78,795,931.20
210101	Үндсэн цалин	79,278,197.00	65,616,630.00
210102	Нэмэгдэл	11,338,331.00	7,137,759.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,541,724.00	2,084,000.00
210104	Урамшуулал	-	3,957,542.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,583,891.10	9,849,491.58
210201	Тэтгэврийн даатгал	8,803,878.54	6,697,654.34
210202	Тэтгэмжийн даатгал	945,002.99	787,959.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	756,002.59	630,367.47
210204	Ажилгүйдлийн даатгал	189,000.44	157,591.84
210205	Эрүүл мэндийн даатгал	1,890,006.54	1,575,918.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,516,800.00	10,922,800.00
210301	Гэрэл, цахилгаан	720,000.00	720,000.00
210304	Байрны түрээс	9,796,800.00	10,202,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,043,103.00	5,569,600.00
210401	Бичиг хэрэг	1,311,430.00	423,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,783,520.00	2,887,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,002,800.00	1,120,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	945,353.00	1,158,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,500.00	236,000.00
210604	Урсгал засвар	214,500.00	236,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,730,000.00	2,390,000.00
210702	Дотоод албан томилолт	1,730,000.00	2,390,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,257,889.91	568,090.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,550,461.91	-



210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,500.00	161,090.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	424,828.00	407,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>350,000.00</b>	<b>130,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	130,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,437,263.99</b>	<b>45,613,087.22</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,841,200.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,841,200.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,596,063.99</b>	<b>45,613,087.22</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,596,063.99	45,613,087.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>=</b>	<b>=</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>=</b>	<b>=</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>=</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	48,946,929.70	-	86,446,929.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,500,000.00	-	48,946,929.70	-	86,446,929.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	30,898,164.80	-	30,898,164.80
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	79,845,094.50	-	117,345,094.50
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	79,845,094.50	-	117,345,094.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,500,000.00	-	79,845,094.50	-	117,345,094.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(23,427,857.74)	-	(23,427,857.74)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	56,417,236.76	-	93,917,236.76



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,755,000.00	106,841,912.78	(44,913,087.22)	70.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,755,000.00	106,841,912.78	(44,913,087.22)	70.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,755,000.00	106,841,912.78	(44,913,087.22)	70.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,540,700.00	78,795,931.20	(39,744,768.80)	66.47
210101	Үндсэн цалин	92,813,800.00	65,616,630.00	(27,197,170.00)	70.70
210102	Нэмэгдэл	15,990,500.00	7,137,759.00	(8,852,741.00)	44.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,920,400.00	2,084,000.00	(1,836,400.00)	53.16
210104	Урамшуулал	5,816,000.00	3,957,542.20	(1,858,457.80)	68.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,017,800.00	9,849,491.58	(5,168,308.42)	65.59
210201	Тэтгэврийн даатгал	10,212,100.00	6,697,654.34	(3,514,445.66)	65.59
210202	Тэтгэмжийн даатгал	1,201,400.00	787,959.31	(413,440.69)	65.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	961,100.00	630,367.47	(330,732.53)	65.59
210204	Ажилгүйдлийн даатгал	240,300.00	157,591.84	(82,708.16)	65.58
210205	Эрүүл мэндийн даатгал	2,402,900.00	1,575,918.62	(826,981.38)	65.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,922,800.00	10,922,800.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	720,000.00	720,000.00	-	100.00
210304	Байрны түрээс	10,202,800.00	10,202,800.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,089,600.00	5,089,600.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	423,500.00	423,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,887,300.00	2,887,300.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,120,800.00	1,120,800.00	-	100.00
210408	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	658,000.00	658,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	236,000.00	236,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	236,000.00	236,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,250,000.00	1,250,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	1,250,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	568,100.00	568,090.00	(10.00)	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,100.00	161,090.00	(10.00)	99.99
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	407,000.00	407,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,000.00	130,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн	130,000.00	130,000.00	-	100.00



	дадлага хийх				
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	151,755,000.00	107,541,912.78	(44,213,087.22)	70.08
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	151,755,000.00	106,841,912.78	(44,913,087.22)	70.40
131001	Улсын төсвөөс санхүүжих	151,755,000.00	106,841,912.78	(44,913,087.22)	70.40
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>700,000.00</b>	<b>700,000.00</b>	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	700,000.00	700,000.00	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	11.00	8.00	3.00	72.70
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	6.00	3.00	66.60
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>11.00</b>	<b>8.00</b>	3.00	72.70
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	6.00	3.00	66.60
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	2.00	-	100.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,640,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,640,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,140,000.00
210702	Дотоод албан томилолт	1,140,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,640,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,640,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,140,000.00



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хараа-Ерөө сав газрын захиргаа нь “Сав газрын усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усны ухаалаг менежментийг хэрэгжүүлсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай салбартаа манлайлагч хамт олон байх” зорилго дэвшүүлэн, Усны тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хараа голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээ, Ус үндэсний хөтөлбөр зэрэг арга хэмжээг ханган ажилладаг.

Тус байгууллага 2022 онд Хараа голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээ, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, “Ус” үндэсний хөтөлбөр, Хараа-Ерөө голын сав газарт хамрагдах аймаг, сумд, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого зорилтын хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус захиргаа нь Усны тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглалтыг хориглох тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Засгийн газрын 2012 оны 254 дугаар тогтоол, 2013 оны 326 дугаар тогтоол, 2013 оны 327 дугаар тогтоол, 2013 оны 389 дугаар тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоол, 2021 оны 43 дугаар тогтоол, БОАЖ-ын сайдын 2019 оны 143 дугаар тушаал, 2015 оны 146 дугаар тушаал, 2015 оны 152 дугаар тушаал, Хараа-Ерөө голын сав газрын захиргааны даргын А/01 дүгээр тушаал, 2022 оны А/47 дугаар тушаал, 2022 оны А/31 дугаар тушаал, зэрэг холбогдох хууль тогтоомжийн дагуу гарсан дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төрийн хэмнэлтийн тухай хууль*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга*
- *Төрийн албаны тухай хууль /нэмэлт өөрчлөлт орсон/*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /нэмэлт өөрчлөлт орсон/*

Төсвийн шууд захирагч төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хараа-Ерөө голын сав газрын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус захиргааны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хараа-Ерөө голын сав газрын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,427.9 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	14,144.5	12,776.4	(1,368.1)
Үндсэн хөрөнгө	103,200.6	81,140.8	(22,059.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>117,345.1</b>	<b>93,917.2</b>	<b>(23,427.9)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	117,345.1	93,917.2	(23,427.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>117,345.1</b>	<b>93,917.2</b>	<b>(23,427.9)</b>

Бараа материалын данс 1,368.1 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн бууралтад тайлант оны 22,271.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлжээ.

Засгийн газрын хувь оролцоо 93,971.2 мянган төгрөг болж, 23,427.9 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус захиргааны 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр 269,967.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд

шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 114,288.1 мянган төгрөгөөр бууруулж 155,409.5 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд дээрх төсөвт 4 удаа өөрчлөлт оруулж, хамгийн сүүлд 3,654.5 мянган төгрөгөөр бууруулж, 151,755.0 мянган төгрөгөөр тодотгон баталжээ. Энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг бууруулсантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 151,755.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 151,755.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 106,841.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 44,913.0 мянга, мөн туслах үйл ажиллагааны орлогоос олсон 700.0 мянга, нийт 45,613.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 106,841.2 мянган төгрөг буюу 70.4 хувьтай гарсан нь орон тоо дутуугаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг зарцуулаагүйтэй холбоотой байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70404	Усны нөөц, нуур, гол, мөрний менежмент	151,755.0	106,841.9	(44,913.0)	70.4
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	151,755.0	106,841.9	(44,913.0)	70.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх онд буцаан төвлөрүүлсэн Төв аймгийн БОАЖГ, мөн сумдын засаг даргын тамгын газартай хамтарсан ажлын гэрээний гүйцэтгэлээр зарцуулаагүй үлдэгдэл 1,140.0 мянга, дээд шатны захирагчаас 500.0 мянга, нийт 1,640.0 мянган төгрөг төвлөрснийг холбогдох зардалд зориулалтын дагуу зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 8 дугаар тоот албан бичгээр 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 151,755.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,276.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээд шатны төсвийн захирагч ТШЗ-ийн батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 8,274.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 791.2 мянга, томилолт, зочны зардлыг 119.0 мянга, нийт 9,184.9 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 5,000.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй 151,519.0 мянган төгрөгийн 12 орлогын гүйлгээг байршуулж, зарлага болон хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гүйлгээ хийгдээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэж байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төлбөрийн акт тогтоох, албан шаардлага, зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй байна.

##### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар төлбөрийн акт тогтоох, албан шаардлага, зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно